

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ОРА-2026/072/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Эрдэнэт хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва  
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оргилмөрөн  
Утас: 70357955 Цахим хаяг: orgilmurung@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,  
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033  
Утас: (976) 7035 9826

Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.02 № 08  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ОРХОН АЙМГИЙН ОЮУ  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Г.БОЛОРМАА ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Оюу цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 77,699.3 мянган төгрөгийг байр ашиглалттай холбоотой санхүүжилт авсан байна.

#### Аудитын гол асуудал

Тайланд онд Баян-Өндөр сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 287,089.5 мянган төгрөгийн засвар, гадна тохижилтын ажил гүйцэтгэснийг хүлээн авч санхүүгийн тайланд капиталжуулан бүртгэсэн байна.

#### Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийг төлөвлөгөөг 9 зорилт 37 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 90.0 хувьтай үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит

612505086

гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдээс зүй бусаар нөлөөлөх нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

	/төгрөгөөр/	
Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>278,913,223.47</u></b>	<b><u>125,181,234.40</u></b>
<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	163,137,955.87	38,137,539.00
Банкинд байгаа бэлэн мөнгө	163,137,955.87	38,137,539.00
Төгрөг	163,137,955.87	38,137,539.00
Төрийн сангийн харилцах	163,137,955.87	38,137,539.00
<b>АВЛАГА</b>	0.00	99,000.00
Бусад авлага	0.00	99,000.00
Байгууллагаас авах авлага	0.00	99,000.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	115,775,267.60	86,944,695.40
Түүхий эд материал	105,775,267.60	86,714,695.40
Тусгай зориулалттай материал	105,775,267.60	86,714,695.40
Хангамжийн материал	10,000,000.00	230,000.00
Аж ахуйн материал	0.00	230,000.00
Барилгын засварын материал	10,000,000.00	0.00
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,253,234,062.50</u></b>	<b><u>2,455,226,127.12</u></b>
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,253,234,062.50	2,455,226,127.12
Биет хөрөнгө	2,061,434,062.50	2,263,426,127.12
Барилга, байгууламж, орон сууц	2,285,235,856.24	2,572,325,394.24
Хуримтлагдсан элэгдэл	-297,762,269.06	-356,670,648.66
Машин тоног төхөөрөмж (компьютер)	125,770,171.80	122,017,071.80
Хуримтлагдсан элэгдэл	-62,149,572.09	-81,182,193.33
Тавилга, аж ахуйн эд хогшил	107,683,757.40	110,483,757.40
Хуримтлагдсан элэгдэл	-97,343,881.79	-103,547,254.33
Биет бус хөрөнгө	191,800,000.00	191,800,000.00
Програм хангамж	1,230,000.00	1,230,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-1,230,000.00	-1,230,000.00
Бусад биет бус хөрөнгө	191,800,000.00	191,800,000.00
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,532,147,285.97</u></b>	<b><u>2,580,407,361.52</u></b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,532,147,285.97</u></b>	<b><u>2,580,407,361.52</u></b>
Засгийн газрын хувь оролцоо	2,532,147,285.97	2,580,407,361.52
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191,800,000.00	191,800,000.00
Өмч: - төрийн	191,800,000.00	191,800,000.00
Хуримтлагдсан үр дүн	601,793,376.21	650,053,451.76
Өмнөх үеийн үр дүн	601,793,376.21	601,793,376.21
Тайлант үеийн үр дүн	0.00	48,260,075.55
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,738,553,909.76	1,738,553,909.76
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,532,147,285.97</u></b>	<b><u>2,580,407,361.52</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

	/төгрөгөөр/	
Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>1,557,705,507.00</u></b>	<b><u>1,844,715,400.50</u></b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>106,114,107.00</u></b>	<b><u>426,338,700.50</u></b>
Нийтлэг татварын бус орлого	106,114,107.00	426,338,700.50
Төсөв байгууллагын өөрийн орлого	51,392,241.00	123,457,662.50
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,392,241.00	123,457,662.50
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	34,910,656.00	287,089,538.00

Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,811,210.00	15,791,500.00
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,451,591,400.00</b>	<b>1,418,376,700.00</b>
<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,368,060,100.00	1,340,677,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,368,060,100.00	1,340,677,400.00
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	83,531,300.00	77,699,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	83,531,300.00	77,699,300.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,472,963,456.23</b>	<b>1,793,247,827.69</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,472,963,456.23</b>	<b>1,793,247,827.69</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,462,105,829.92	1,778,081,159.87
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,002,876,625.43	1,254,996,535.51
Цалин	670,132,905.41	707,518,791.58
Цалингийн тусгай нэмэгдлүүд	332,743,720.02	547,477,743.93
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	125,736,071.64	156,559,635.52
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	107,792,065.12	131,638,728.52
Эрүүл мэндийн даатгал	17,944,006.52	24,920,907.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	52,864,173.69	52,943,740.52
Гэрэл, цахилгаан	12,669,296.83	12,135,688.32
Түлш, халаалт	26,801,586.83	28,548,440.90
Цэвэр, бохир ус	13,393,290.03	12,259,611.30
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	23,269,229.00	38,829,072.20
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,098,500.00	15,791,500.00
Бараа материал акталсны зардал	12,170,729.00	23,037,572.20
<b>Нормативт зардал</b>	136,158,840.00	136,669,000.00
Хоол, хүнс	136,158,840.00	136,669,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,809,500.00	20,192,800.00
Урсгал засвар	9,809,500.00	20,192,800.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,758,500.00	5,099,700.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,758,500.00	5,099,700.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	109,632,890.16	112,790,676.12
Бараа үйлчилгээний бусад зардал	15,481,043.00	16,841,600.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,380,700.00	10,500,100.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	83,771,147.16	85,448,976.12
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	10,857,626.31	15,166,667.82
<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	0.00	14,758,759.48
Төвлөрүүлэх шилжүүлэг		14,758,759.48
<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	10,857,626.31	407,908.34
Төвлөрүүлэх шилжүүлэг	10,857,626.31	407,908.34
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>84,742,050.77</b>	<b>51,467,572.81</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	43,291.72	3,207,497.26
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	43,291.72	3,207,497.26
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-43,291.72	-3,207,497.26
<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>84,698,759.05</b>	<b>48,260,075.55</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,502,983,641.00</b>	<b>1,541,834,362.50</b>
<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>51,392,241.00</b>	<b>123,457,662.50</b>

Нийтлэг татварын бус орлого	51,392,241.00	123,457,662.50
Төсөв байгууллагын өөрийн орлого	51,392,241.00	123,457,662.50
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,392,241.00	123,457,662.50
<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,451,591,400.00</b>	<b>1,418,376,700.00</b>
Улсын төвлөрсөн төсвөөс	1,368,060,100.00	1,340,677,400.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,368,060,100.00	1,340,677,400.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	83,531,300.00	77,699,300.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	83,531,300.00	77,699,300.00
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,390,030,380.07</u></b>	<b><u>1,663,275,779.37</u></b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,390,030,380.07</b>	<b>1,663,275,779.37</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,379,172,753.76</b>	<b>1,648,109,111.55</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,002,876,625.43	1,254,996,535.51
Цалин	670,132,905.41	707,518,791.58
Цалингийн тусгай нэмэгдлүүд	332,743,720.02	547,477,743.93
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,736,071.64	156,658,635.52
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	107,792,065.12	131,737,728.52
Эрүүл мэндийн даатгал	17,944,006.52	24,920,907.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,864,173.69	52,943,740.52
Гэрэл, цахилгаан	12,669,296.83	12,135,688.32
Түлш, халаалт	26,801,586.83	28,548,440.90
Цэвэр, бохир ус	13,393,290.03	12,259,611.30
Нормативт зардал	136,158,840.00	136,669,000.00
Хоол, хүнс	136,158,840.00	136,669,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	19,809,500.00	9,996,800.00
Урсгал засвар	19,809,500.00	9,996,800.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,733,500.00	5,099,700.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,733,500.00	5,099,700.00
Бараа үйлчилгээний бусад зардал	38,994,043.00	31,744,700.00
Бараа үйлчилгээний бусад зардал	26,148,343.00	21,244,600.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,845,700.00	10,500,100.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,857,626.31</b>	<b>15,166,667.82</b>
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	14,758,759.48
Төвлөрүүлэх шилжүүлэг		14,758,759.48
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,857,626.31	407,908.34
Төвлөрүүлэх шилжүүлэг	10,857,626.31	407,908.34
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>112,953,260.93</u></b>	<b><u>-121,441,416.87</u></b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,466,850.00</b>	<b>3,559,000.00</b>
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,466,850.00</b>	<b>3,559,000.00</b>
Дотоод эх үүсвэрээр	8,466,850.00	3,559,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,466,850.00	3,559,000.00
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-8,466,850.00</u></b>	<b><u>-3,559,000.00</u></b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>104,486,410.93</b>	<b>-125,000,416.87</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	58,651,544.94	163,137,955.87
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	163,137,955.87	38,137,539.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,800,000.00	1,738,553,909.76	517,094,617.16	2,447,448,526.92
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,800,000.00	1,738,553,909.76	517,094,617.16	2,447,448,526.92
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	84,698,759.05	84,698,759.05
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,800,000.00	1,738,553,909.76	601,793,376.21	2,532,147,285.97
<b>2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>191,800,000.00</b>	<b>1,738,553,909.76</b>	<b>601,793,376.21</b>	<b>2,532,147,285.97</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	191,800,000.00	1,738,553,909.76	601,793,376.21	2,532,147,285.97
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	48,260,075.55	48,260,075.55
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>191,800,000.00</b>	<b>1,738,553,909.76</b>	<b>650,053,451.76</b>	<b>2,580,407,361.52</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,644,145,400.00</b>	<b>1,588,727,571.03</b>	<b>55,417,828.97</b>	<b>96.6</b>
УРСГАЛ ЗАРДАЛ	1,644,145,400.00	1,588,727,571.03	55,417,828.97	96.6
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,644,145,400.00</b>	<b>1,588,727,571.03</b>	<b>55,417,828.97</b>	<b>96.6</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,282,161,700.00	1,254,996,535.51	27,165,164.49	97.9
Цалин	760,238,800.00	707,518,791.58	52,720,008.42	93.1
Цалингийн тусгай нэмэгдлүүд	521,922,900.00	547,477,743.93	-25,554,843.93	104.9
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>159,467,400.00</b>	<b>156,658,635.52</b>	<b>2,808,764.48</b>	<b>98.2</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	133,835,500.00	131,737,728.52	2,097,771.48	98.4
Эрүүл мэндийн даатгал	25,631,900.00	24,920,907.00	710,993.00	97.2
<b>Нормативт зардал</b>	<b>160,754,800.00</b>	<b>136,669,000.00</b>	<b>24,085,800.00</b>	<b>85.0</b>
Хоол, хүнс	160,754,800.00	136,669,000.00	24,085,800.00	85.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,683,700.00</b>	<b>5,099,700.00</b>	<b>584,000.00</b>	<b>89.7</b>
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,683,700.00	5,099,700.00	584,000.00	89.7
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>36,077,800.00</b>	<b>35,303,700.00</b>	<b>774,100.00</b>	<b>97.9</b>
Бараа үйлчилгээний бусад зардал	25,577,700.00	24,803,600.00	774,100.00	97.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,500,100.00	10,500,100.00	0.00	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,644,145,400.00</b>	<b>1,588,727,571.03</b>	<b>55,417,828.97</b>	<b>96.6</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,345,297,300.00</b>	<b>1,340,677,400.00</b>	<b>4,619,900.00</b>	<b>99.7</b>
Улсын төсвөөс санхүүжих	1,345,297,300.00	1,340,677,400.00	4,619,900.00	99.7

<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	298,848,100.00	248,050,171.03	50,797,928.97	83.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	151,206,200.00	123,049,754.16	28,156,445.84	81.4
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	147,641,900.00	125,000,416.87	22,641,483.13	84.7
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		163,137,955.87		
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		38,137,539.00		
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>1.00</b>	<b>1.0</b>
Төсвийн байгууллага	1	1	1.00	1.0
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>44</b>	<b>44</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
Удирдах ажилтан	2	2	0.00	100.0
Гүйцэтгэх ажилтан	21	21	0.00	100.0
Үйлчлэх ажилтан	21	21	0.00	100.0
<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	<b>328</b>	<b>328</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
<b>СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА</b>	<b>328</b>	<b>328</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
Төрийн өмчит СӨБ байгууллага	328	328	0.00	100.0
<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>44</b>	<b>44</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	28	28	0.00	100.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1	0.00	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15	15	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн дансны төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	77,699,300.00	62,940,540.52	14,758,759.48	81.0
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	77,699,300.00	62,940,540.52	14,758,759.48	81.0
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	77,699,300.00	62,940,540.52	14,758,759.48	81.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	67,699,300.00	52,943,740.52	14,755,559.48	78.2
Гэрэл, цахилгаан	17,024,500.00	12,135,688.32	4,888,811.68	71.3
Түлш, халаалт	36,868,800.00	28,548,440.90	8,320,359.10	77.4
Цэвэр, бохир ус	13,806,000.00	12,259,611.30	1,546,388.70	88.8
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,000,000.00	9,996,800.00	3,200.00	100.0
Урсгал засвар	10,000,000.00	9,996,800.00	3,200.00	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	77,699,300.00	62,940,540.52	14,758,759.48	81.0
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	77,699,300.00	62,940,540.52	14,758,759.48	81.0
Орон нутгийн төсвөөс	77,699,300.00	62,940,540.52	14,758,759.48	81.0

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 3,707.9 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс 3,707.9 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 6-р сард давхардаж орж ирсэн, буцааж шилжүүлэхээр тодруулсан боловч тодорхой хариу өгөөгүй, эргэж нэхэмжлээгүй, тооцоо нийлж харилцан баталгаажуулаагүй, ирэх онд төлөх эсэх нь тодорхойгүй 210.0 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж тусгасан,
- Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын татварын жилийн эцсийн тайланд нийт цалинг 3,497.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн байна.

Аудитаар нийт 5,571.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 1,716.4 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 1,086.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2,768.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

Татварын хөнгөлөлт илүү эдлүүлсэн, цалин хөлс илүү бодож олгосон, төсвийн орлого бүрдүүлэхтэй холбоотой нийт 1,716.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоов.

### 3.2 Албан шаардлага

Орон нутгийн нэмэгдэлд зориулан аймгаас олгосон санхүүжилтийг орон нутгийн төсөвт 1,086.0 мянган дутуу төвлөрүүлсэнд албан шаардлага өгөв.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Авлагын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Нийгмийн даатгалын шимтгэлд илүү шилжүүлж НДШ-ийн тайлангаар авлага үүссэн 99,000 төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үүссэн авлагыг нэн даруй барагдуулж, цаашид төсвийг зохистой удирдаж авлага үүсгэхгүй ажиллах.

#### 2. Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд буюу зардлын бүлэг хооронд нийт 1,953,619.74 төгрөг зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6-д "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Өгсөн зөвлөмж:** Төсвийн сар, улирлын хуваарийг баримталж, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулахгүй байх.

### 3. Зардлын данстай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тус цэцэрлэг нь 2025.12.11-өдөр хүлээж авсан үхрийн махнаас оны эцэст хоол, хүнсний материалын үлдэгдэлгүй гарах зорилгоор, хүүхдийн ирцийн бууралтаас шалтгаалан зарцуулагдаагүй үлдсэн 716,300 төгрөгийн 49.4кг махыг бэлтгэн нийлүүлэгчийн 2025.12.11-ны өдрийн зарлагын падаанаас хасуулан анхан шатны баримтыг дахин бүрдүүлсэн, материалын үлдэгдлийг баталгаажуулахаар хяналтын тооллогоор очиж асуудлыг илрүүлсэн аудиторт бодитой бус, зөрүүтэй мэдээлэл өгсөн. Дээрх махыг 2026 оны 01-р сард хүлээн авснаар баримт бүрдүүлж орлогыг хойшлуулсан тул махны үнийг бүрэн төлөөгүй, санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.3-д "бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтыг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх, хүнсний материал түүний дотор үнийн дүн өндөр махан бүтээгдэхүүн хүлээн авах хяналтыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх.

### Дөрөв. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

**Тав. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Орхон аймгийн Оюу цэцэрлэг	1	210.0			1	210.0	1	210.0				
	1	3,497.9			1	3,497.9	1	3,497.9				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3,707.9</b>			<b>2</b>	<b>3,707.9</b>	<b>2</b>	<b>3,707.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орхон аймгийн Оюу цэцэрлэг	1	514.0	1	514.0								
	1	871.7	1	871.7								
	1	330.7	1	330.7								
	1	1,086.0			1	1,086.0						
	1	1,953.6					1	1,953.6				
	1	716.3					1	716.3				
	1	99.0					1	99.0				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>5,571.2</b>	<b>3</b>	<b>1,716.4</b>	<b>1</b>	<b>1,086.0</b>	<b>3</b>	<b>2,768.9</b>				